



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 4/128

Мяндалговь

Г Хөрөнгө гаргах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, "Соёлын өвийг хамгаалах тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3 дахь заалт болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 05 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Төв Халхын дуулалт жүжгийн театрын "Дуурьсал" хамтлагийн уран бүтээлчдийн "Дуутай хууртай нутаг усныхан минь" уран бүтээлийн шинэ цомгийг аймгийн бэлэг дурсгалын зүйлд зориулан авахад хөрөнгө гаргасугай.

Хоёр. Цомог нэг бүрийн үнийг 15000 /Арван таван мянга/ төгрөгөөр тооцон, 500 ширхэгийг авахад шаардагдах 7500000 /Долоон сая таван зуун мянга/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга /Ц.Эрдэнэсүрэн/, нягтлан бодогч /Г.Мөнхбаясгалан/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0200436